



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

Хүн амын амьжиргааны 2022 оны  
доод түвшинг тогтоох тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний Статистикийн хорооны даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хүн амын амьжиргааны доод түвшин"-ий 2022 онд мөрдөх хэмжээг хавсралтаар баталж, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Шинэчлэн баталсан "Хүн амын амьжиргааны доод түвшин"-г захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, нийтэд мэдээлэхийг Тамгын газар (Б.Лхагва)-т даалгасугай.



Б.БАТДАВАА

142823100097

Үндэсний статистикийн хорооны даргын  
2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн  
А/!!! дугаар тушаалын хэвсрэлт



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төгрөг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	238800
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	240400
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	239200
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	236400
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	277800